



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 9 сарын 24 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/437 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-т “Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээний техник, тоног төхөөрөмж” нийлүүлэх тендер /НХААГ-19/090/-ийн Багц-1: Өөрөө буулгагч ачааны автомашин 2ш /20-24 тн/, усны машин сордог 2ш /10 тн/, халуун уураар үлээгч /шугам хоолойн хөлдөлт гэсгээх тусгай зориулалтын тоног төхөөрөмж/ нийлүүлэх НХААГ-19/090-1/1 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэгчээр сонгон шалгарсан “Хустайн хишиг” ХХК-аас нийлүүлэх хөрөнгийг хүлээн авах ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.


2. “Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-т нийлүүлэгдэж буй машин, механизмыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны .᠘. дүгээр сарын ᠒᠘. өдрийн ᠗/᠒. дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Рэнцэнбямба	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын орлогч дарга
Гишүүд:	С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн, ашиглалт удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч
	Н.Сайнбаяр	“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын Засвар ашиглалтын албаны дарга
	П.Мөнхдэлгэр	“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ-ын автын инженер
Нарийн бичгийн дарга:	Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн